

ЭРҮҮЛ МЭНДИЙН СЭДВЭЭР БИЧИХЭД АНХААРАХ
ЁС ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

М. Одмандах*

* МУБИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D).

Түлхүүр үг: сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, ёс зүйн алдаа, хэм хэмжээ, хувь хүний нууц, эрүүл мэнд, ХДХВ/ДОХ.

Оршил

Монголын сэтгүүл зүй өнөөдөр хөгжлийн шинэ шатанд гарч нэлээд зүйл өөрчлөгдөн, жам ёсоороо хөгжиж яваа хэдий ч санаатайгаар болон санаандгүй байдлаар хүний эрх зөрчсөн, бусдын нэр төр, алдар хүнд, хувь хүний нууцыг задруулсан мэдээлэл түгээсэн хэргээр сэтгүүлчид нэлээд тохиолдолд шүүхийн хаалга татсаар байна. 2002 онд “Үг” сонины эрхлэгч ХДХВ/ДОХ-оор халдварласан байж болзошгүй гэх нэгэн эмэгтэйн тухай хүнээс авсан мэдээллээ тодруулалгүйгээр нийтэлсний төлөө тэр эмэгтэй найзынхаа гарт амь алдаж, түүний хоёр өнчин хүүхэд

үлдэж, элэг бүтэн байсан нэгэн гэр бүл сүйдсэн билээ.

Энэ юунаас болсон бэ? Энэ тохиолдолд сэтгүүлч ямар алдаа гаргаж, дээрх эмгэнэлт байдал бий болсон тухай бид төдийлөн яриагүй бөгөөд харин сэтгүүлч шоронд хоригдох болсонд л харамсаж, сэтгүүлчид дуу хоолойгоо нэгтгэж, өмгөөлж, хамгаалж, шоронд орсных нь төлөө сэтгүүлч эмэгтэйг магтан алдаршуулж, шагнаж урамшуулж, албан тушаал дэвшүүлж байсан нь саяхан. Гэтэл уг чанараар нь хөөж үзвэл сэтгүүлч эмэгтэйн гаргасан мэргэжлийн ноцтой алдааны үрээр, үнэн худал нь тодорхойгүй мэдээллийн балгаар нэгэн сайхан эмэгтэй амь насаа алдсан байдаг. Тэрбээр хүн амины хэрэг гарах нөхцлийг бүрдүүлсний төлөө ч биш, хүнийг гүтгэсэн хэргээр шинэ Эрүүгийн хуулийн дагуу зургаан сар ял эдэлсэн байдаг.

Ийм байдалд орохгүй байх боломж байв уу? Байсан гэж хэлье. Учир нь бид сэтгүүл зүйн мэргэжлийн зарчмаа зөрчилгүй, ёс зүйн хэм хэмжээг сахин баримталсан бол дээрх явдал гарахгүй байх байлаа. Тиймээс энэ удаа сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйд хувь хүний нууц болон эрүүл мэндийн байдлыг хэрхэн мэдээлэх тухай заасан товчхон танилцуулхыг зорьсон болно.

Сэтгүүлчид бид ёс зүйн зарчим болон хуулийн зохих мэдлэгтэй байж гэмээ нь хүний эрхийг зөрчилгүй, мэргэжлийн ноцтой алдаа гаргахгүй ажиллах бодит боломж бүрдэнэ гэж үзэж байна. Гагцхүү ёс зүйтэй байж, ёс зүйн зарчмаа баримтлах нь зөв зам мөн.

Сэтгүүлчдийн ёс зүйн зарчмын заалтууд

Сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүй нь ажил, үйл ажиллагаандаа зайлшгүй дагаж мөрдвөл зохих, мэргэжлийн алдаа гаргахгүй байх цорын ганц хамгаалалт гэдгийг хүн бүр ойлгох нь чухал байна. Хэрвээ сэтгүүлч мэргэжлийн зарчмаа ягштал баримтлаж, ёс зүйн хэм хэмжээ зөрчихгүй хүнлэг байж чадвал хуулийн ямарваа нэгэн цээрлэл хүлээхгүй явах боломж бий.

Сэтгүүлчдийн сонирхол татдаг, мэдэхийг хүсдэг сэдвийн нэг нь хувь хүний амьдрал. Энэ бол мөнхийн сэдэв. Тиймээс бид энэ байдлаас болж мэргэжлийн алдаа гаргаж, хүний хувийн нууцад халдсан, хүний нэр төр гутаасан, унагасан хэргээр зэм хүртэх нь олонтаа. Энэ байдлыг цэгцлэх үүднээс олон улсын төвшинд ч, манайд ч ялгаагүй сэтгүүлч-

«

Сэтгүүлчдийн сонирхол татдаг, мэдэхийг хүсдэг сэдвийн нэг нь хувь хүний амьдрал. Энэ бол мөнхийн сэдэв. Тиймээс бид энэ байдлаас болж мэргэжлийн алдаа гаргаж, хүний хувийн нууцад халдсан, хүний нэр төр гутаасан, унагасан хэргээр зэм хүртэх нь олонтаа.

»

дийн ёс зүйн зарчмыг батлаж, хүний эрх, хувийн нууц, өвчин шаналалд өртсөн хүнд хэрхэн хандвал зохихыг тусгайлан заасан байдаг. Гагцхүү ёс зүйтэй хүн л ёс зүйтэй сайн сэтгүүлч болж чадна.

1. 1989 оны хоёрдугаар сарын 25-нд хуралдсан Монголын Сэтгүүлчдийн Холбооны II бүгд хурлаар хэлэлцэж баталсан **“Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим”**-д:

II. Мэргэжлийн ёс зүйн зарчим, хэм хэмжээнд харш зүйл гэсэн хэсэгт:

“11. Бие хүний хувийн нууц, ахуй амьдралтай нь холбоотой мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлбэл ёс зүй зөрчсөн гэж үзэх” тухай дурджээ.

2. 1996 онд хуралдсан Монголын Сэтгүүлчдийн Холбоо, Монголын Чөлөөт Ардчилсан Сэтгүүлчдийн Эвлэл-

лийн нэгдсэн их хурлаар баталсан **“Монголын сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн зарчим”**-д:

“8. Дараах зүйлийг сэтгүүлч мэргэжлийн ноцтой алдаанд тооцно. Үүнд:

...Бусдыг гүтгэх, нэр төрийг нь гутаах, нэр хоч өгч доромжлох, хүнийг ул үндэсгүй буруутгах...”

3. 2003 оны 2-р сарын 22-нд хуралдсан Монголын чөлөөт сонинуудын холбооны Бага хурлаас тунхагласан **“Сэтгүүлчийн ёс зүйн зарчим”**-д

“Хариуцлага, давхар хариуцлага хүлээнэ

10. Хүүхэд, өвчтөн, хариуцлага хүлээх чадваргүй хүнээс мэдээлэл авахдаа эцэг эх, асран халамжлагчаас зөвшөөрөл авна. Өвчтөний талаар мэдээлэхдээ уг хүний өвчний түүх, хувийн нууцад халдахыг цээрлэнэ”.

4. 2005 оны 3-р сарын 11-ний өдөр хуралдсан Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн II Их хурлаар баталсан **“Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим”**-д:

“...Хоёр. Мэргэжлийн ноцтой алдаа гаргахгүйн төлөө ажиллана

• Бусдыг гүтгэх, доромжлох, нэр төр гутаахыг цээрлэнэ

Долоо. Хувийн нууц, бусдын зовлон шаналалыг ойлгож, хүнлэг энэрэнгүй ёсыг ямагт сахина...” гэж хүн ёсны үүднээс хандаж, ёс зүйтэй байхыг тунхагласан байдаг.

5. **“Английн Хэвлэлийн эсрэг санал гомдлын комиссын үйл ажиллагааны дүрэм”**-д:

Бүх хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээг өндөр төвшинд сахин баримтлах үүрэгтэй.

Энэхүү дүрэмд:

“Хувийн амьдрал, хувь хүний нууц

Хувь хүний амьдрал, хувийн аливаа нууц асуудлыг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр зөвхөн дараах тохиолдолд л хэвлэн нийтэлж олон нийтэд хүргэж болно. Үүнд:

a. Гэмт хэргийг илчлэх болон ноцтой гэмт хэрэг илрүүлэхэд холбогдолтой бол,

b. Нийгэм, олон нийтийн эсрэг ноцтой гэмт хэргийг илрүүлэхэд,

c. Олон нийтийн аюулгүй байдал ба эрүүл мэндийг хамгаалах,

d. Хувь хүн болон олон нийтийг аливаа төөрөгдөлд орохоос урьдчилан сэргийлэх сануулга дохио болгох мэдээлэл.

Эмнэлэгт

1. Сэтгүүлчид, гэрэл зурагчид нь эмнэлэг болон түүнтэй төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын гадны хүн орохыг хориглосон бүсэд нэвтрэхдээ зохих зөвшөөрөл авсан байх.

2. Эмнэлэг болон түүнтэй төстэй үйл ажиллагаа эрхлэн явуулдаг газарт нэвтрэх өөрийн зорилгыг танилцуулах”.

6. АНУ-ын Мэргэжлийн сэтгүүлчдийн Нийгэмлэгээс (Сигма Делта Чи, 1987) гаргасан “Ёс зүйн хэм хэмжээний жагсаалт”-нд:

“V. Шударга зарчим: Сэтгүүлчид нь мэдээ цуглуулах, нэвтрүүлэх явцад хамрагдсан хүмүүсийн, хувийн нууц, эрхийг ямагт бодолцож, тэдний хүндэтгэж байх ёстой.

...2. Хувь хүний нууцад харшилсан, түүн рүү довтолсон тохиолдолтой хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэмцэх ёстой”.

Тайлбар:

Дээрх ёс зүйн зарчмууд нь сэтгүүлч хүний зайлшгүй дагаж мөрдөж, мэргэжлийн алдаа гаргахгүй байхад замчлах ёстой тунхаг, зарчим хэдий ч энэ бүхнийг манай сэтгүүлчид үл ухамсарласнаас мэргэжлийн алдаанд хүрч, хүний эрхийг зөрчих тохиолдол гарч байна.

Сэтгүүлчдийн хувьд сенсацитай мэдээний төлөө мэргэжлийн ёс зүйгээ зөрчиж байгаа нь бидний хувьд хамгийн том бэрхшээлийн нэг болоод байгаа бөгөөд одоо Монголд Хэвлэлийн консулын тухай ярьж байгаа нь цаг үеэсээ хоцорсон зүйл болоод байна. Сэтгүүлчдийн ёс зүйгүй үйлдэл нь тэднийг хуулийн хатуу заалтаар шийтгүүлэх нөхцөл боломжийг бий болгосон гэж хэлж болно. Өөрсдөө бид ийм байдалд хүртэл ёс жудаггүй загнасан атлаа ниргэсэн хойно нь

хашгирав гэгчээр Эрүүгийн хуулин дахь хатуу заалтыг өөрчлөхийн төлөө тэмцэж байна. Бид эрх мэдэлтнүүдэд олзлогдож, бусдын идэш болохын оронд өөрсдийн батласан Ёс зүйн хэм хэмжээг л сахин биелүүлэх, сэтгүүл зүйн мэргэжлийн зарчмаа дагаж мөрдөх нь хэний ч дарамтанд өртөхгүй байх нэгэн боломж мөн гэж дахин хэлмээр байна.

Сэтгүүлчдийн хууль эрх зүйн мэдлэг дулимаг, дээрх хуулийн заалтыг мэдэхгүйгээс зарим тохиолдолд зөрчиж бусдын нэртөрийг гутаах, гүтгэх гэх мэт мэргэжлийн ноцтой алдааг гаргадаг байна. Тиймээс цаашид хувь хүний нууцад хамаарах эрүүл мэндийн асуудлаар бичихдээ аливаа өвчнийг хэнд ч тохиолдож болох зүйл хийгээд ХДХВ/ДОХ-оор халдварласан хүнийг гэмт хэрэгтэн биш зөвхөн өвчинд нэрвэгдсэн жирийн нэгэн хүн гэдэг талаас хандаж мэдээлж байх нь сэтгүүлчид мэргэжлийн ноцтой алдаа гаргахгүй байх боломжийг бүрдүүлнэ.

Сэтгүүлчид бусдад үнэнийг, гагцхүү үнэнийг мэдээлэх, баримттай өгүүлэх үүднээс ХДХВ/ДОХ-ын халдвар авсан хүмүүсийг хэн болох, хэдэн настай, хаана амьдардаг зэргийг мэдэхийг чармайдаг нь бодит байдал дээр зөрчил үүсгэж, халдвар авсан хүний эрхийг бүдүүлгээр зөрчих ноцтой алдаанд хүргэх нэгэн шалтгаан болж

байгааг цаашид анхаарах хэрэгтэй байна.

Зав муутай сэтгүүлчид маань номын санд сууж хууль судлах боломжгүй. Гэвч зайлшгүй мэдвэл зохих хуулийн талаар сэтгүүлчдэд зориулсан гарын авлага хэд хэд гарсан байдгийг олж авах юм уу, эсвэл интернэтээс хэрэгтэй хуулиа татан авч үзэхээс гадна байнга хэрэглэх хуулийг татаж авч тусгай мэдээллийн сан, бааз байгуулах боломжийг ашиглавал бидний хуулийн мэдлэг дээшилнэ.

Уг нь 2005 оны хавар ЭМЯ болон сэтгүүлчид хамтран ДОХ-ын талаар хэвлэл мэдээллээр бичихдээ мэргэжлийн ёс зүйгээ баримтлах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах харилцан ойлголцлын бичигт гарын үсэг зурсан хэдий ч сэтгүүлчид ДОХ-ын талаар нийгмийн сэтгэл зүйд буруу хандлага төрүүлэхүйц мэдээ, мэдээлэл хийсээр байгааг хэлэх хэрэгтэй.

Та бүхэнд хэрэг болох байх гэсэн үүднээс ХДХВ/ДОХ-ын талаар мэдээ мэдээлэл бэлтгэхдээ баримтлах дараах зарчмуудыг дахин сануулж байна.

ДОХ-ын талаар бичихэд баримтлах үндсэн таван зарчим

Эдгээр зарчмыг ХДХВ-ын халдварын тархалттай холбоотой асуудлаар мэдээлэл боловсруулагчид, хэвлэн нийтлэгчдэд зориулан ДЭМБ-аас нэрд

гарсан, алдартай сэтгүүлчидтэй хамтран боловсруулжээ.

1. Үнэн зөв мэдээлэл хүргэ

ХМХ бол олон нийтийг мэдээллээр хангах хүчирхэг бөгөөд чухал эх үүсвэр билээ. Буруу мэдээлэл болон төөрөгдөл нь хүмүүсийн өөрийгөө хамгаалах боломжийг хязгаарлаж, айдас түгшүүр, ялгаварлан гадуурхах явдалд хүргэдэг. Аль нэгэн мэдээллийн үнэн зөв эсэхийг өөрөө дүгнэж цэгнэхийн тулд маш их зүйл судалж мэдэх шаардлагатай. Иймд эмч, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, хүмүүст үнэн зөв мэдээлэл хүргэ.

2. Бодитой бай

БЗДХ ба ХДХВ/ДОХ нь яс үндэс, нас хүйс, мэргэжил, зиндааг огт ялгахгүй. Бүх зүйл тухайн хүний биеэ авч явах байдал, зан үйлээс шалтгаална. Хэрэв та ДОХ/БЗДХ-аар ядуучууд, гомосекс, биеэ үнэлэгч гэх мэт тодорхой бүлгийн хүмүүс өвчилдөг гэсэн ойлголт хүмүүст өгвөл "Бид аюулгүй юм байна" гэсэн буруу сэтгэгдэл төрж болзошгүй юм. Энэ нь мөн "Аюултай эрсдэлтэй бүлэг" гэсэн буруу үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгаан болж магадгүй.

3. Бусдын хувийн нууцыг хүндэл

Та БЗДХ болон ХДХВ/ДОХ-той хүмүүсийн овог нэр, хаяг, хувийн бусад мэдээллийг тэдний зөвшөөрөлгүй дэлгэн тавьснаараа тэдэнд маш их уршиг тарьж магадгүй юм. Таны буруу үйлдлээс болж тэр хүнийг ажлаас нь халах, гэрээс нь хөөх, эрх чөлөөнд нь халдах

зэрэг явдал тохиолдож болзошгүй. Нууцыг чандлан хадгалах, хүний эрх болон тухайн хүний хувийн амьдралыг хүндэтгэх зарчмыг байнга сахих ёстой.

4. Зориудын дуулианаас зайлсхий

Ихэнх сэтгүүлчид сүр дуулиантай үйл явдлыг эрж хайдаг бөгөөд үүнд муу зүйл мэдээж байхгүй. Гэхдээ БЗДХ болон ХДХВ/ДОХ-ын хувьд зориудын сүр дуулиан нь нийгэмд хий хоосон айдас төрүүлж, сэтгэлийн асар их хямралд хүргэдгийг санах хэрэгтэй. Хий хоосон айдас нь БЗХӨ болон ХДХВ-ын халдварын тархалтыг зогсоох бүх үйл ажиллагаанд саад тотгор болдог. Үүний оронд халдвар хэрхэн дамждаг болон дамждаггүй, халдвараас сэргийлэх боломж, арга замын тухай үнэн зөв, тодорхой мэдээлэл өгөх нь дэмий айж сүрдэхийг зогсооно.

5. Шинэ боломж дэвшүүл

Эрүүл мэндийн төвүүд, ТББ-ууд, сайн дурын идэвхтэн, сургагчид, БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх, мэдээлэл, тусламж, үйлчилгээ хүргэдэг олон байгууллага, хүмүүс бий. Тэдэнтэй нягт хамтран ажиллаж, эдгээр үйлчилгээнд хамрагдахыг хүмүүст уриалж, санал

болгох хэрэгтэй. Энэ нь тэдэнд шинэ шинэ боломж нээж өгнө.

Дүгнэлт

Энэ бүхнээс товчхон дүгнээд хэлэхэд бид сэтгүүлчийн ёс зүйн зарчмаа сайтар судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж, аливаад бодитой хандах юм бол ямар нэгэн алдаа эндэгдэл гарахгүй байх боломжтой юм. Ялангуяа эрүүл мэнд, тэр дундаас ХДХВ/ДОХ-ын тухай мэдээлэхдээ дээр дурдсан зарч-

«
Сэтгүүлчид бусдад үнэнийг, гагцхүү үнэнийг мэдээлэх, баримттай өгүүлэх үүднээс ХДХВ/ДОХ-ын халдвар авсан хүмүүсийг хэн болох, хэдэн настай, хаана амьдардаг зэргийг мэдэхийг чармайдаг нь бодит байдал дээр зөрчил үүсгээс, халдвар авсан хүний эрхийг бүдүүлгээр зөрчих ноцтой алдаанд хүргэх нэгэн шалтгаан болж байгааг цаашид анхаарах хэрэгтэй байна.

»

мыг дагаж, хуулийн хүрээнд хувь хүний нууцыг хүндэтгэн, бүхнийг мэдэх гэсэн сониуч зангаа түр зуур дарах аваас элдэв асуудалд орооцолдохгүй байх боломж байгааг анхаарах хэрэгтэй байна.

БЗДХ ба ХДХВ/ДОХ нь яс үндэс, нас хүйс, мэргэжил, зиндааг огт ялгахгүй. Бүх зүйл тухайн хүний биеэ авч явах байдал, зан үйлээс шалтгаална гэдгийг бусдад ухамсарлуулж чадвал нийгэмд байгаа буруу ойлголтыг засаж залруулж, бусдад хүндэтгэлтэй харьцах боломжийг олгохоос гадна өвчинд нэрвэгдсэн хүмүүсийн шаналалыг ойлгож, хүнд хүн ёсоор

хандах нь сэтгүүлч бидний эрхэм үүргийн нэг гэж бодож байна.

Хавсралт

ХДХВ/ДОХ-ын талаар сэтгүүлчдэд өгч, тэднээр дамжуулан нийгмийн сэтгэхүйд зөв хандлага тогтоон төлөвшүүлэх зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сангаас ДОХ-той тэмцэх үндэсний сантай хамтран боловсруулсан "ХДХВ/ДОХ. Сэтгүүлчдэд зориулсан мэдээлэл ба лавлагаа" хэмээх гарын авлагыг 2004 онд хэвлүүлсэн байдаг бөгөөд "Сэтгүүлчид юу хийж чадах вэ?" хэсэгт ДОХ-той тэмцэхэд тэдний гүйцэтгэх үүргийг дараах байдлаар тодорхойлсон байдаг байна.

- Олон түмэнд, уншигч, үзэгч, сонсогчиддоо, ялангуяа хүүхэд залуучуудад ХДХВ/ДОХ-ын талаар үнэн зөв, бодитой мэдээлэл түгээж, өөрийгөө болон бусдыг ДОХ-оос хамгаалах чадвартай болоход нь туслах;

- ДОХ-той холбоотой доромжлол, ялгаварлан гадуурхалт, амаа хамхисан байдлыг эцэс болгох, айдас хүйдсийг бус, эвлэрэл нэгдэл бий болгоход олон түмнийг уриалан дуудах;

- ДОХ-той тэмцэх, сэргийлэх үр дүнтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хөрөнгө мөнгө гаргахад нь бодлого боловсруулагчдад нөлөөлөх;

- Нийгмийн өртөмтгий байдлыг бууруулах, мэдээлэл, үйлчилгээг эмчилгээг хүртээмжтэй болгоход баримт

нотолгоонд суурилсан бүтээл бичиж нийтлэх;

- Өндөр эрсдэл бүхий хүмүүсийн эрхийг хамгаалах, хүний эрхэд суурилсан арга барилыг дэмжих, тэдний талаар нийгэмд эерэг уур амьсгал бүрдүүлэхэд дуу хоолойгоо гаргах;

- ДОХ-той тэмцэх байгууллагуудтай сайн дураараа ажиллах хэмээн томъёолсон байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *С о в д Г.* ба бусад. 2000. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ.

2. *Д а л а й ж а м ц Г.* 2004. ХДХВ/ДОХ-той хүмүүсийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохын эсрэг асуудал // "Хүний эрхийн үндэсний комисс гурван жилд 2001-2003". УБ.

3. *О т г о н ц э ц э г С.* 2006. Эрүүл мэндийн сэтгүүл зүйн үндэс. УБ.

4. 1996. Хэвлэл мэдээлэлтэй холбоотой хууль зүйн заалтууд. Эмхэтгэсэн Т.Баасансүрэн. УБ.

5. *Ө л з и й с а й х а н Л.* 2006. Монгол улсын хуулиуд (Хуулийн 100 асуулт, хариулт 1.) УБ.

Резюме

В данной статье автор уделяет внимание освещению в СМИ проблем, связанных со здоровьем населения, самым актуальным и болезненным из которых является СПИД. В нашей стране уже имело место случаи, когда публикация непроверенных фактов о якобы большой СПИДом женщине повлекло за собой печальные последствия: жертва журналистской небрежности была убита, а главный редактор газеты попала за решётку. Однако, как считает автор, можно было избежать подобных взрывоопасных ситуаций, если бы журналист следовал своим профессиональным этическим принципам.